

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР АШИГ  
/2019-2020 ОН/-д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2021/57-ШТА-ГА

---

Баянхонгор 2021 он

Тэргүүлэх аудитор: **Б.Мөнхбат**

Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: **А.Цээням**

Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор: **М.Алтантуяа**

Утас: 99061861 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Аудитор: **Н.Бунчинсүрэн**

Утас: 99049866 Цахим хаяг: [bunchinsuren@audit.gov.mn](mailto:bunchinsuren@audit.gov.mn)

Аудитор: **М.Гансүм**

Утас: 89997921 Цахим хаяг: [gansumm@audit.gov.mn](mailto:gansumm@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 9/18

Номгон

**Тайлан баталгаажуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр ашиг /2019-2020 он/-т хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Шууд тайлагнах аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /М.Алтантуяа/-д үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймаг, сумдын Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /М.Алтантуяа/, аудитор /Н.Бүнчинсүрэн/ нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /А.Цээням/-д тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б. МӨНХБАТ



Тушаал-2020

005010018

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудиторын 2021 оны 09 дүгээр  
сарын 15- ны өдрийн А/18 тоот тушаалын хавсралт

НИЙЦЛИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын нэр: “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр ашиг 2019-2020”

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага
А	1	2	3	4	5
1	Өлзийт сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 08 дугааруудтай зээл барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн иргэнээс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй.	183/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	10000.0		10000.0
2	Гурванбулаг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 02, 03, 04, 05, 06, 07, 11 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	184/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	58000.0		58000.0
3	Гурванбулаг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгчтэй байгуулсан 04 дугаартай зээл, барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн иргэнээс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй.	185/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	4000.0		4000.0
4	Шинэжинст сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан нийт 8 гэрээнд бүгд үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан байх боловч эдгээрийг хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	186/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	164000.0		164000.0

A	1	2	3	4	5
5	Эрдэнэцогт сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 66, 67, 69, дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	187/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	26300.0		26300.0
6	Богд сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 06 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй.	188/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	5000.0		5000.0
7	Галуут сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 20/04, 20/08, 20/09 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	176/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	30000.0		30000.0
8	Жинст сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 04, 05, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 15, 17 дугааруудтай барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	177/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	100000.0		100000.0
9	Жинст сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 07 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасаны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй.	178/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	3000.0		3000.0
10	Жинст сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 08, 09, 17 дугааруудтай барьцааны зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй.	179/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	42000.0		42000.0

A	1	2	3	4	5
11	Хүрээмарал сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 04, 05, 09, 2020 оны 09 дугааруудтай зээл барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч барьцааны гэрээнүүдийг хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	180/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	31000.0		31000.0
12	Хүрээмарал сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 06 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй	181/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	3000.0		3000.0
13	Өлзийт сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 02 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй	182/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	5000.0		5000.0
14	Богд сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 02, 03, 06, 07, 09, 10, 11 мөн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 02, 03 дугааруудтай зээлийн гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	165/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	69000.0		69000.0
15	Баянлиг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 02, 06, 08, 10, 11, 14, 15 дугааруудтай зээл барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	166/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	42000.0		42000.0
16	Баянлиг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 06, 08, дугааруудтай зээл барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн иргэнээс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй	167A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	15000.0		15000.0

A	1	2	3	4	5
17	Баацагаан сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 19/16, 19/19 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	169/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	5500.0		5500.0
18	Бөмбөгөр сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгчтэй байгуулсан 123 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй	170/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	4000.0		4000.0
19	Бөмбөгөр сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгчтэй байгуулсан 122 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй	171/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	5000.0		5000.0
20	Бөмбөгөр сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 03, 06, 07, 08, 112, 114, 116, 117, 120, 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 121, 122, 123, 126, 127, 128, 129, 132, 133, 135 дугааруудтай барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	172/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	96000.0		96000.0
21	Заг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгчтэй байгуулсан 05 дугаартай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх тухай хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй.	173/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	7000.0		7000.0
22	Жаргалант сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 19/01, 19/02, 19/04, 19/05 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	174/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	29000.0		29000.0

A	1	2	3	4	5
23	Жаргалант сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 19/02 дугаартай зээл, барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хөрөнгийг барьцаалах эрхийг олгосон зөвшөөрөл, итгэмжлэлийг хийлгэх талаар хуульд заасан шаардлагыг иргэнд тавьж ажиллаагүй байна.	175/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	8000.0		8000.0
24	Галуут сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 20/04, 20/08, 20/09 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	176/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	30000.0		30000.0
25	Баянхонгор сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны 19/09, 19/10, 19/22, 19/25 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх тухай хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй	152/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	45000.0		45000.0
26	Баянхонгор сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 19/10, 19/25 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгүүдийг барьцаалсан боловч хуульд заасны дагуу тухайн хөрөнгийн хамтран өмчлөгч тус бүрийн зөвшөөрлийг бичгээр аваагүй байна	153/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	15000.0		15000.0
27	Баянхонгор сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 19/03, 19/09, 19/10, 19/12 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хөрөнгийг барьцаалах эрхийг олгосон зөвшөөрөл, итгэмжлэлийг хийлгэж гэрээнд хавсаргаагүй	154/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	47000.0		47000.0
28	Баян-Овоо сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 01,02,06, 07 дугааруудтай барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	155/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	61000.0		61000.0

A	1	2	3	4	5
29	Баянбулаг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 76, 78, 80 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	156/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	25000.0		25000.0
30	Баянбулаг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 82 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй.	157/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	4000.0		4000.0
31	Баянбулаг сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 80, 82 дугааруудтай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй	158/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	10000.0		10000.0
32	Баян-Өндөр сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 19/01, 19/05, 19/06 дугааруудтай зээл, барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээнүүдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй	159/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	17000.0		17000.0
33	Баян-Өндөр сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 19/01 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс уг хөрөнгийг барьцаалуулах эрхийг олгосон зөвшөөрөл, итгэмжлэлийг хуульд заасны дагуу авч гэрээнд хавсаргаагүй	160/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	7000.0		7000.0
34	Баянцагаан сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 05 дугааруудтай барьцааны гэрээнд зээлдэгчийн бус гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан боловч тухайн өмчлөгчөөс хуульд заасны дагуу зөвшөөрөл, итгэмжлэлийг авч гэрээнд хавсаргаагүй	161/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	10000.0		10000.0

A	1	2	3	4	5
35	Баянцагаан сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 03, 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 05, 08 дугааруудтай барьцааны гэрээнд зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй	162/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	19500.0		19500.0
36	Баянцагаан сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 02, 03, 05, 2020 оны зээлдэгч нартай байгуулсан 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 14, 16, 17 дугааруудтай барьцааны гэрээнд холбогдох журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан боловч уг барьцааны гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй.	163/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	94803.3		94803.3
37	Богд сумын Засаг даргаас Сум хөгжүүлэх сангийн 2019 оны зээлдэгчтэй байгуулсан 04 дугаартай барьцааны гэрээнд зээлдэгчийн хуваарьт өмч бус дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалсан боловч хуульд заасны дагуу хамтран өмчлөгч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аваагүй	164/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	6000.0		6000.0
38	Баянхонгор сумын СХС-ийн 2020 оны санхүүгийн тайланд авлагыг 563.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан байхад аудитаар зээлдэгч тус бүрээр хувийн хэрэгтэй тулган авлагын тооцооллыг давтан гүйцэтгэхэд 578.6 сая төгрөг буюу 15.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	189/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	15276.7		15276.7
39	Баян-Овоо сумын сум хөгжүүлэх сангаас 2019 онд 3 зээлдэгчдэд 80.0 сая төгрөгийн зээл олгох гэрээ байгуулсан боловч 2019 онд 35,9 сая төгрөг, 2020 онд 5.0 сая төгрөг олгож зээлийн гэрээг шинэчлэн байгуулаагүй байна.	190/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	40920.0		40920.0
40	Баянхонгор сумын Сум хөгжүүлэх сангаас 2018-2020 онд зээл авсан 17 зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, 79.8 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.	142/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	79801.8	79801.8	

A	1	2	3	4	5
41	Баянхонгор сумын Сум хөгжүүлэх сангаас 2019 онд “Уран бичлэг, жааз үйлдвэрлэх” зориулалтаар иргэн Э.Д нь 10.0 сая төгрөгийн, иргэн Ж.Б нь “Гоёл” оёдлын цех өргөжүүлэх зориулалтаар 8.0 сая төгрөгийн, иргэн Б.М нь “Оёдол” –ын зориулалтаар 6.0 сая төгрөгийн зээл авсан бөгөөд 2021.08.19-ны байдлаар дээрх зээлдэгчид төслийн зориулалтаар үйл ажиллагаа явуулаагүй ба 2021.08.19-ны өдрийн байдлаар нийт зээл, хүүгийн авлага 16.7 сая төгрөг байна.	143/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	16709.1	16709.1	
42	Богд сумын Сум хөгжүүлэх сангаас 2019 онд “Хүнсний дэлгүүр” зориулалтаар иргэн Н.А-д 3.0 сая төгрөгийн зээл олгосон ба 2020.12.31-ны байдлаар зээл, хүүгийн авлагын үлдэгдэл 2.2 сая төгрөг байна	144/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	2163.7	2163.7	
43	Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангаас 2019 онд иргэн Л.Н-д “Супермаркет” хүнсний дэлгүүрийн зориулалтаар 4.0 сая төгрөгийн зээл олгосон ба 2020.12.31-ны байдлаарх зээл, хүүгийн авлагын үлдэгдэл 4.3 сая төгрөг байна.	145/A0560237/БНА-2021/57/ШТА-ГА	4294.0	4294.0	
<b>ДҮН</b>			<b>1320665.3</b>	<b>102968.6</b>	<b>1209300.0</b>

оОо

**Тайланг хянасан:****Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар****Дарга, тэргүүлэх аудитор****Б.Мөнхбат****Аудитын менежер****А.Цээням****Тайланг бэлтгэсэн:****Ахлах аудитор****М.Алтантуяа****Аудитор****Н.Бунчинсүрэн****М.Гансум****2021 оны 08 дугаар сарын 31****Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: [www.audit.mn](http://www.audit.mn)****Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584 дугаарын утсаар харилцана уу.****ХАЯГ:****Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар  
Аймгийн ЗДТГ-ын байр,  
Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг-  
64000  
Монгол Улс****АГУУЛГА**

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	2
Товчилсон үгийн тайлбар	3
АУДИТЫН ДҮН	4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	4
Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг сумын ИТХ-аар үндэслэлгүй баталж, хүрэх үр дүн тодорхой бус төслүүдийг сонгон шалгаруулсан байна.	4
1.1 СХС-ийн хөрөнгийг журамд заасны дагуу зээл, хүүгийн орлогын эх үүсвэрийг тусад нь төлөвлөөгүйгээс СХС-ийн үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн хүүгийн орлогын 30 хувиар тооцож ИТХ-аар батлуулах боломжгүй болсон байна.	4
1.1.2 СХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчид зээлийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу зээл, хүүгийн орлогыг 2019 онд 81.1 хувь, 2020 онд 88.5 хувь нь төлсөн байна.	6
1.2.1 Сумын сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг журмын 3.3.3 -д заасан бүрэлдэхүүнээр шинэчлэн байгуулах шаардлагатай байна	10
1.2.2 Сумд сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг ИТХ-аар баталж байгаа боловч ихэнх сумын төсөл сонгон шалгаруулах комисс ямар салбарт зээлийн эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, хүрэх үр дүн, ажлын байр нэмэгдүүлэх тооцоолол тодорхой бус төслүүдийг сонгон шалгаруулжээ	10
1.2.3. Баянхонгор аймгийн сумдын "Сум хөгжүүлэх сан"-аас зээлдэгч нартай байгуулсан зээл, барьцааны гэрээнүүд нь "Иргэний хууль"-ийн 56 дугаар зүйл, 156 дугаар зүйл, "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн 9, 10, 11, 53 дугаар зүйл, "Хөдлөх эд хөрөнгө болох эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн 10 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангахгүй байна.	12
1.2.4 Баянхонгор аймгийн хэмжээнд СХС-аас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн нийт авлагын 50 дээш хувь нь хугацаа хэтэрсэн 7 сум байгаа нь сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийн барагдуулалт хангалтгүй байгааг харуулж байна.	13
1.2.5 Баянхонгор аймгийн ихэнх сумын СХС-аас олгосон зээл өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэгдсэн, Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2020 оны тайлангаар 141 ажлын байр шинээр нэмэгдэж 79 ажлын байр хадгалагдсан гэж байгаа боловч дээрх ажлын байрууд нь нийгмийн даатгалаар баталгаажуулаагүй байна	15
<b>Зарим сумын хяналтын зөвлөл сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, тайланг ИТХ-аар тайлагнаж хэлэлцүүлээгүй байна.</b>	18
2.1.1 Сумдын хяналтын зөвлөл "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн хэрэгжилт, үр дүнд" хяналт тавиагүй, сумын ИТХ-д ажлаа тайлагнаагүй байна.	18
2.1.2 Сумдын СХС-аас авсан зээлийн мэдээллийг СХС-ийн программд оруулахдаа санхүүгийн тайланд байгаа зээл, зээлийн хүүгийн авлагаас зөрүүтэй оруулж, зээлдэгч нартай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулахгүй байна.	18
2.1.3 Зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа барагдуулаагүй, төсөл хөтөлбөрийг зориулалт бусаар зарцуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцоогүй байна.	20
2.2.1 Өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн актын биелэлт 85 хувь, Монгол банкны мэдээллийн санд орсонтой холбоотойгоор чанаргүй зээл 78.9 сая төгрөгөөр төлөгдсөнийг аудитын үр өгөөжөөр хүлээн зөвшөөрч бүртгэлээ.	22
<b>АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	24
<b>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ</b>	26
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	28



## АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн  
үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан, "Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай", Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны А/04 дугаар тушаалыг үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зээл олголтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнасан уу?

Аудитын хамарсан  
хүрээ

Аудитыг сумдын Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналтад сумын ЗДТГ, орон тооны бус зөвлөлөөс хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ.

Аудитад сумдын СХС, ИТХ, орон тооны бус зөвлөл, 2019-2020 онд СХС-гийн хөрөнгөөр төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 400, 4000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, "Төрийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим" MNS 6817-7:2020 "Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг баримтлан аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтан, төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх



Аудитад ашигласан  
шалгуур үзүүлэлт

Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа

Хүндрэл бэрхшээл

ААН  
ЗДТГ  
ЖДУ  
ИТХ  
ИНХ  
НА  
СХС  
СТСХ  
ТЕЗ

зэрэг аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”
- Аймаг, сумын ИТХ-ын тогтоол
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, аудитор Н.Бүнчинсүрэн, М.Гансум нар гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2021 оны 06 дугаар 30-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 01-09-ны өдөр, 08 дугаар сарын 08-25-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж /7-р сарын 09-өөс 8-сарын 18-ны хооронд аудиторуд ээлжийн амралттай байсан/, тайлагналын үе шатны ажлыг 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 31-ны хугацаанд гүйцэтгэж, тайланг Газрын дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, сумдын Засаг даргад /цахимаар/ хүргүүлэв.

Аймаг орон нутагт Ковид цар гарсантай холбогдуулан хөдөө сумдад хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг объект дээр нь үзэх боломжгүй нөхцөл, хүндрэл бэрхшээл үүссэн.

Товчилсон үгийн тайлбар

Аж ахуйн нэгж  
Засаг даргын тамгын газар  
Жижиг дунд үйлдвэрлэл  
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал  
Иргэдийн нийтийн хурал  
Нийцлийн аудит  
Сум хөгжүүлэх сан  
Санхүү, төрийн сангийн хэлтэс  
Төсвийн ерөнхийлөн захирагч



## АУДИТЫН ДҮН

### ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сум хөгжүүлэн санг Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг баримтлан ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн /СХС/ хөрөнгийн сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйл ажиллагааг өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан.

Хөнгөлөлттэй нөхцөл: Арилжааны банкаар дамжихгүй, сумын ИТХ-аар батлагдсан Төслийг сонгон шалгаруулах комисс 9 хүний бүрэлдэхүүнтэй шалгаруулж, сумын Засаг даргын захирамжаар төсөл хэрэгжүүлэгч нартай гэрээ байгуулан 3 жилийн хугацаатай жилийн 3 хүртэл хувийн хүүтэйгээр сум хөгжүүлэх сангаас шууд санхүүжүүлдэг, барьцаа хөрөнгийн баталгааг арилжааны банкнаас уян хатан нөхцөлтэй, зээлийн гэрээг орлогын эх үүсвэрээс хамааруулан хийх боломжтой, сумын хөгжилд тасралтгүй эргэх санхүүгийн эх үүсвэр бүрдсэн давуу талтай байна.

Аудитаар Ковид-19 цар тахлаас шалтгаалан сумдад олгосон зээлдэгч нарын үйл ажиллагааг газар дээр нь үзэх боломжгүй байсан ба аудитад хамрагдах үеийн баримтад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба сумдад шалгалтыг 2021 оны 5-6 сард хийсэн тул бид аудитад зээлдэгчийн хувийн хэрэг холбогдох бичиг баримтыг татаж авч аудитад хамруулан шалгалаа.

**Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг сумын ИТХ-аар үндэслэлгүй баталж, хүрэх үр дүн тодорхой бус төслүүдийг сонгон шалгаруулсан байна.**

1.1 СХС-ийн хөрөнгийг журамд заасны дагуу зээл, хүүгийн орлогын эх үүсвэрийг тусад нь төлөвлөөгүйгээс СХС-ийн үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн хүүгийн орлогын 30 хувиар тооцож ИТХ-аар батлуулах боломжгүй болсон байна.

1.1 Сум хөгжүүлэн сангаас Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 2.1<sup>1</sup>-д заасны дагуу сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор хөнгөлөлттэй зээлийн хэмжээ болон зээл олгох эх үүсвэрийг 2019 онд 2969.5 сая төгрөг, 2020 онд 2486.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөж баталсан байна.

<sup>1</sup>үлсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, сангаас олгосон зээлийн хүүгийн орлого; хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги



## БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2019-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Сая.төгрөг

Он	СХС-ийн орлогын төлөвлөгөө			Зардлын төлөвлөгөө		
	Зээл, хүүгийн эргэн төлөлтөөс	Урд оны үлдэгдлээс	Дүн	Зээл олголт	Үйл ажиллагааны зардал	Дүн
2019	1,772.4	1,197.2	2,969.6	2,947.3	22.3	2,969.6
2020	1,499.0	987.5	2,486.5	2,480.7	5.8	2,486.5

## Аудитын илрүүлэлт

- СХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө үндсэн зээл, хүүгийн орлогыг салгаж төлөвлөөгүйгээс журмын 2.1<sup>2</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөвхөн зээлийн эргэн төлөлт болон өмнөх оны харилцах даны үлдэгдлээс эх үүсвэрийг төлөвлөн, зээлийн хүүгийн орлого болон зээлийн хүүгийн алдангиас эргэн төлөгдөх эх үүсвэрийг тооцон төлөвлөхгүй байна.
- СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нарт мэргэжил арга зүйн сургалт явуулах үйл ажиллагааны зардлын хэмжээг журмын 1.8<sup>3</sup> дахь аргачлалаар тооцоогүй, СХС-аас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтөд хяналтын зардал, зээл авагчдад зориулсан сургалтын зардал зэрэг СХС-ийн үйл ажиллагааны зардлыг 2019 онд 12 сум 22.3 сая төгрөг, 2020 онд 4 сум 5.8 сая төгрөгийг баталсан ба бусад сумын СХС үйл ажиллагааны зардлаа сумын ИТХ-аар батлуулаагүй байна. Иймд журмын 2.1 болон 1.8 дахь заалтыг хэрэгжүүлэн СХС-ийн эх үүсвэрийг зээлдэгч бүрийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу үнэн зөв төлөвлөж, СХС-ийн үйл ажиллагааны /сургалт, хяналт/ зардлын төсвийг сумын ИТХ-аар батлуулж байх зөвлөмжийг сумдын Засаг нарт хүргүүлж байна.

Гүйцэтгэлээр СХС-д 2019 онд зээлийн эргэн төлөлтөөс 1081.0 сая төгрөг, зээлийн хүүгийн орлогоос 75.5 сая төгрөг, өмнөх оны харилцах дансны үлдэгдэл 1429.3 сая төгрөг нийт 2582.9 сая төгрөгийн эх үүсвэрийг, 2020 онд зээлийн эргэн төлөлтөөс 1316.2 сая төгрөг, зээлийн хүүгийн орлогоос 30.1 сая төгрөг, өмнөх оны харилцах дансны үлдэгдэл 1103.0 сая төгрөг нийт 2449.4 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлсэн байна.

Доорх хүснэгтээс харахад 2019 онд Баянбулаг, Баянцагаан, Эрдэнэцогт, Галуут сумаас бусад сумдын СХС-ийн зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогын төлөвлөгөө биелээгүй, зээл, хүүгийн эргэн төлөлтийн дундаж хувь 73 хувь ба 2020 онд зээл, хүүгийн эргэн төлөлтийн дундаж хувь 97 хувь болж 24 хувиар нэмэгдсэн байна.

<sup>2</sup> 2.1.1. улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, 2.1.3. сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, 2.1.4. хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги

<sup>3</sup> Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

СУМДЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2019-2020 ОНЫ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ  
/сая.төгрөг/

Д/Д	Байгууллаг нэр	2019 оны зээл, хүүгийн эргэн төлөлт				2020 оны зээл, хүүгийн эргэн төлөлт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Галуут СХСан	56.2	67.2	(11.0)	120%	97.6	49.3	48.3	51%
2	Баян-овоо СХСан	86.0	29.8	56.2	35%	60.0	28.6	31.4	48%
3	Эрдэнэцогт СХСан	50.4	61.0	(10.6)	121%	63.3	49.8	13.5	79%
4	Бууцагаан СХСан	76.1	41.2	34.9	54%	100.0	12.9	87.1	13%
5	Жинст СХСан	62.0	54.9	7.1	89%	95.5	57.3	38.2	60%
6	Богд СХСан	78.5	69.4	9.1	88%	81.6	71.8	9.9	88%
7	Баянлиг СХСан	53.0	43.0	9.9	81%	36.0	49.8	(13.9)	139%
8	Баянговь СХСан	34.2	23.1	11.1	68%	25.0	24.7	0.3	99%
9	Гурванбулаг СХСан	110.5	26.1	84.4	24%	95.4	56.0	39.4	59%
10	Жаргалант СХСан	128.0	36.3	91.7	28%	124.1	55.9	68.1	45%
11	Заг СХСан	40.0	31.2	8.8	78%	21.0	58.1	(37.1)	277%
12	Баацагаан СХСан	160.9	57.1	103.8	36%	123.5	54.6	68.9	44%
13	Бөмбөгөр СХСан	62.5	46.5	16.0	74%	53.0	70.4	(17.4)	133%
14	Өлзийт СХСан	81.3	56.9	24.5	70%	50.8	50.2	0.7	99%
15	Хүрээмарал СХСан	134.7	47.6	87.1	35%	65.3	46.5	18.8	71%
16	Баянбулаг СХСан	30.3	47.0	(16.6)	155%	70.0	74.5	(4.5)	106%
17	Шинэжинст СХСан	114.1	18.9	95.2	17%	32.0	28.5	3.4	89%
18	Баянцагаан СХСан	106.0	117.8	(11.8)	111%	55.0	84.8	(29.8)	154%
19	Баян-өндөр СХСан	91.8	74.5	17.3	81%	72.2	65.6	6.6	91%
20	Баянхонгор СХСан	215.9	204.1	11.8	95%	177.8	357.0	(179.2)	201%
	Дүн	1,772.4	1,153.7	618.7	73%	1,499.0	1,346.3	152.7	97%

Мөн сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг төлөвлөхдөө зээлдэгч нарын зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай уялдуулахгүй, тухайн жилд олгох зээлийн хэмжээтэй хамааруулан төлөвлөдөг, зээл авсан иргэд зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, холбогдох албан тушаалтнууд хяналтын үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, зээлийг хугацаанд нь төлүүлэх талаар санаачилгагүй ажилласан зэргээс СХС-ийн зээл, хүүгийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 2019 онд 618.7 сая төгрөгөөр, 2020 онд 152.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

1.1.2 СХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчид зээлийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу зээл, хүүгийн орлогыг 2019 онд 81.1 хувь, 2020 онд 88.5 хувь нь төлсөн байна.

Сумдын СХС-гийн харилцах дансны үлдэгдэл 2019 оны эхэнд 1429.3 сая төгрөг ба 2020 оны эцэст 1477.8 сая болж 48.5 сая төгрөгөөр өссөн нь 2020 онд зээл, хүүгийн эргэн төлөлт 235.2 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдэж, 2020 онд СХС-аас олгох хөнгөлөлттэй зээл өмнөх оноос 507.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.



## СХС-ийн 2019-2020 оны харилцах дансны мэдээлэл

Сая.төгрөг

Он	Эхний үлдэгдэл	Орлого			Зарлага		Эцсийн үлдэгдэл
		Зээлийн эргэн төлөлт	Хүүгийн эргэн төлөлт	Бусад	Зээл олголт	ҮА-ны зардал	
2019	1,429.3	1,081.0	75.5	-	1,462.2	20.6	1,103.0
2020	1,103.0	1,316.2	30.1	0.1	945.5	16.7	1,477.8

2019 онд Гурванбулаг сумын СХС-ын харилцах дансны үлдэгдэл 29.1 сая, Заг сумын СХС-ийн харилцах дансны үлдэгдэл 29.3 сая, Шинэжинст сумын СХС-ийн харилцах дансны үлдэгдэл 141.4 сая, 2020 онд Жинст сумын СХС-ийн харилцах дансны үлдэгдэл 6.7 сая, тайлант оны зээл, хүүгийн эргэн төлөлт 57.5 сая, Баянлиг сумын СХС-ийн харилцах дансны үлдэгдэл 70.4 сая зээлийн эргэн төлөлт 49.9 сая, Өлзийт сумын СХС-ийн харилцах дансны үлдэгдэл 74.2 сая зээл хүүгийн эргэн төлөлт 50.2 сая, Баянхонгор сумын СХС-ийн үлдэгдэл 116.3 сая, зээл хүүгийн эргэн төлөлт 356.9 сая төгрөг, Баянговь сум СХС-аас 2011-2018 онд олгосон зээл, хүүгийн авлага хугацаа хэтэрсэн шалтгаанаар 2019-2020 онд СХС-аас зээл олгоогүй байгаа нь дээрх сумд зээл олгох эх үүсвэр хангалттай байхад зээл олгоогүй байгаа нь сумын жижиг дунд үйлдвэрлэгч эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээл авах боломжийг олгоогүй байна.

Баянхонгор аймгийн сумдын СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нарын зээл, хүүгийн авлагын үлдэгдэл 2018 оны эцэст 3509.1 сая төгрөг ба 2019 онд 16 сумын СХС-аас 209 төсөлд 1462.2 сая төгрөг, 2020 онд 14 сумын СХС-аас 139 төсөлд 945.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгож 2020 оны жилийн эцсийн байдлаар авлагын үлдэгдэл 3642.9 сая төгрөг байна

## СХС-аас олгосон зээлийн эргэн төлөлт

Он	Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх		Нийт	Харилцах дансанд орсон төлөлт			Нийт	Хэрэгжилт
	Зээл	хүү		Зээл	Хүү	алданги		
2019	1,241.5	184.2	1,425.7	895.5	253.9	7.1	1,156.4	81.1%
2020	1,451.4	59.5	1,510.9	1,265.3	64.9	6.7	1,336.9	88.5%

СХС-аас авсан зээлдэгчийн зээлийн гэрээ, эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөх үндсэн төлбөр, хүү, алдангийг 2019 онд 81.1 хувь, 2020 онд 88.5 хувь төлүүлсэн байна.



## СХС-аас зээл авсан зээлдэгчийн авлагын үлдэгдэл

Он	Зээлдэгчийн тоо	Зээл, хүүгийн нийт авлага		2020.12.31-ны байдлаарх авлагын үлдэгдээс хугацаа хэтэрсэн зээл	Хувь
		2019.12.31	2020.12.31		
2011	8	46.5	35.2	35.2	100%
2012	13	59.6	50.9	50.9	100%
2013	92	309.9	257.0	257.0	100%
2014	66	306.7	256.6	256.6	100%
2015	69	258.1	201.6	201.6	100%
2016	68	221.9	100.7	100.7	100%
2017	170	602.4	263.8	230.9	88%
2018	129	655.2	374.6	105.3	28%
2019	210	1,464.2	1,153.2	145.2	13%
2020	138	0.1	949.1	4.3	0.5%
Нийт	963	3,924.6	3,642.6	1,387.5	38%



Судалгаанаас харахад нийт 2020 оны зээлийн үлдэгдэл 3642.6 сая ба үүнээс зээлийн 38 хувь буюу 1387.5 сая төгрөг хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байгаагаас 54.8 сая төгрөгийн зээл нь нас барсан 11 иргэнтэй холбоотой байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онуудын СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нараас 17 сумын 251 иргэнд зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 605.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 2020 онд 450.6 сая төгрөг, 2021 оны эхний 6 сарын байдлаар 65.2 сая төгрөгийн акт барагдсан, 2020 онд Санхүүгийн хяналт, аудитын албаны “Сумдын Сум хөгжүүлэх сангийн 2019 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад” хийсэн хяналт шалгалтаар 9 сумын СХС-ийн зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагыг төлүүлэхээр 173.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос актын биелэлт 74.8 хувь, 2020 оны СХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Баацагаан сумын сум хөгжүүлэх сангийн 32.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг төлүүлэх төлбөрийн акт тогтоосноос 16.2 сая төгрөгийн төлбөр барагдсан байна.

Баянхонгор сумын СХС-аас 2012-2019 онд хөнгөлөлттэй зээл авсан зээлийн үлдэгдэлтэй 99 төсөл хэрэгжүүлэгч нарын зээлийн гэрээний үүргийн биелэлтийг зээлдэгчийн хувийн хэрэг, харилцах дансны хуулгатай тулган баталгаажуулалт хийсэн. Мөн Баянхонгор сумын СХС нь 2020 онд хөнгөлөлттэй зээл олгоогүй ба 2019 онд 29 төсөлд 278.0 сая төгрөгийн зээл олгосноос аудитаар 4 зээлдэгчийн 18.0 сая төгрөгийн зээл бүрэн төлөгдсөн, зээл хүүгийн хугацаа хэтэрсэн 4 зээлдэгчийн зээлийн гэрээг хугацаанаас өмнө эгүүлэн татаж шүүхэд шилжүүлэн эвлэрлийн гэрээ байгуулсан, 21 зээлдэгчийн үйл ажиллагааг талбар дээр нь очиж зээлдэгч нартай уулзан ярилцлага, тэмдэглэл хийлээ.



БАЯНХОНГОР СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН  
ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН АВЛАГЫН БҮРТГЭЛ /2021 оны 08 сар/  
/сая.төг/

Он	Зээлдэгчийн тоо	Анх олгосон зээл	2021.01.01-ний эхний үлдэгдэл	Үүнээс зээл, хүү		2021 онд төлсөн /8.18-ны байдлаар/	Нийт зээл хүүгийн үлдэгдэл /2021/08/19	Үүнээс			
				Зээл	Хугацаа хэтэрсэн хүү			ШШГГ-т байгаа	Шүүхээр шийдүүлсэн	Шүүхийн шатандаа	Бусад
2012-2013	11	62.00	47.28	45.77	1.51	4.96	42.32	39.95	-	1.13	1.24
2014	12	149.89	115.65	104.54	10.66	27.00	88.65	36.97	36.35	-	15.33
2015	11	53.30	42.18	38.73	5.54	3.73	38.46	21.74	8.00	8.72	-
2016	2	10.00	6.00	5.72	0.28	-	6.00	-	3.28	2.72	-
2017	6	58.00	36.66	31.17	5.49	8.46	28.20	-	16.34	-	11.86
2018	31	304.00	133.13	129.64	3.50	77.09	56.04	-	34.22	-	17.78
2019	26	233.00	196.09	192.59	3.51	26.38	169.72	-	39.26	-	70.56
Нийт	99	870.19	576.99	548.16	30.49	147.62	429.38	98.65	137.46	12.57	116.77

### Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Шүүхийн шүүгчийн шийдвэрээр төлөхөөр тогтоогдсон 18 зээлдэгчийн 98.7 сая төгрөгийн төлүүлэхээр ШШГА-т сумын ЗДТГ-ын даргын албан тоотоор шилжүүлсэн байна.
- Аудитаар зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 17 зээлдэгчийн 79.8 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.
- Баянхонгор сумын СХС-аас 2018 онд зээл авсан 18/27 гэрээний дугаартай зээлдэгч Г.Э-ийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл 3.8 сая төгрөг, 18/04 гэрээний дугаартай зээлдэгч Ч.А-ийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл 1.6 сая төгрөг байхад Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны 5-р сарын 1/205, 1/217 тоот албан бичгээр барьцаа хөрөнгийг чөлөөлсөн ба тус 2 зээлдэгчийн төлөгдөөгүй үлдэгдэл 5.4 сая төгрөгийг 2021.08.31 нд бүрэн төлж дууссан байна. Цаашид зээлийн үлдэгдэлтэй зээлийн барьцааг чөлөөлөхгүй байх зөвлөмжийг сумын Засаг даргад хүргүүлж байна.
- Баянхонгор сумын Засаг даргын 2020.10.26-ны өдрийн 1/563, 2021.04.14-ны өдрийн 1/136 тоот албан бичгээр ШШГА-аас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хааж 4 зээлдэгчийн 30.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл хүүгийн өрийг эгүүлэн татсан ба үүнээс 2021 оны 8 –р сарын 19-ны байдлаар 4.6 сая төгрөг төлөгдөж 26.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Шүүхээс хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагыг албан гүйцэтгэхээр шүүгчийн захирамж гарсан боловч зээлдэгч Х.Б /0,8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өртэй / оршин суух хаяг тодорхойгүй, зээлдэгч П.Ч /9,4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн өртэй/ регистр зөрүүтэй шалтгаанаар ШШГА зээлдэгчийн материалыг хүлээн авахгүй байгаа гэсэн шалтгаанаар тус зээлдэгчийн зээл хугацаа хэтэрсэн хэвээр байна.
- Зээл хүүгийн хугацаа авлагын хэтэрсэн 3 зээлдэгчийн /12,6 сая төгрөг/ оршин суух хаягийг тодруулахаар Баянхонгор аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхээс эрэн сурвалжлах шийдвэр гарсны үндсэн дээр Баянхонгор сумын Засаг даргын 2020.09.11-н өдрийн 1/459, 2020.10.20-ны өдрийн 1/551 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт хандсан ба эрэн сурвалжилж байна.  
Иймд СХС-аас авсан зээлдэгчийн зээл, хүүгийн эргэн төлөлт зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн, зээлийг зориулалт бусаар ашигласан зэрэгт хяналт хийж зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлж байна.



1.2.1 Сумын сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг журмын 3.3.3<sup>4</sup> -д заасан бүрэлдэхүүнээр шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумдын ИТХ-ын тогтоолоор 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгосон байхаар журмын 3.4.1-т заасан боловч сумын ИНХ-аар хэлэлцүүлж сонгоогүй нийтлэг зөрчил байна. Иймд Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд ажиллах багийн төлөөллийг сумын ИНХ-аар хэлэлцэн сонгож журмын 3.4.1<sup>5</sup> заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг сумын ИТХ-ын даргад хүргүүлж байна.

СХС-аас нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг ихэнх сумд 30.0 сая төгрөг хүртэл олгохоор тогтоосон байна.

Төсөл сонгох шалгаруулах орон тооны бус зөвлөл иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн төслийг хүлээн авч хэлэлцэн 2019 онд 212 төслийг шалгаруулж 1462,2 сая төгрөгийн зээл, 2020 онд 139 төслийг сонгон шалгаруулж 945.5 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

1.2.2 Сумд сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг ИТХ-аар баталж байгаа боловч ихэнх сумын төсөл сонгон шалгаруулах комисс ямар салбарт зээлийн эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, хүрэх үр дүн, ажлын байр нэмэгдүүлэх тооцоолол тодорхой бус төслүүдийг сонгон шалгаруулжээ.

Аудитад хамрагдсан 2019-2020 онуудад аймгийн хэмжээнд 18 сумын СХС-ийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь нийт 351 төслийг шалгаруулж хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон байна.

СХС-аас 2019-2020 онд олгосон төслийн тэргүүлэх 10 чиглэл

/сая.төгрөг/

<sup>4</sup> сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулсан, Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах

<sup>5</sup> 3.4.1. зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн сонгосон байх



№	Үйл ажиллагааны төрөл	2019		2020	
		тоо хэмжээ	мөнгөн дүн	тоо хэмжээ	мөнгөн дүн
1	Оёдол	42	214.5	20	107.5
2	Арьс шир, эсгий гар урлал	25	172.0	17	112.5
3	Мужаан	14	145.8	7	37.0
4	Сүү, цагаан идээ үйлдвэрлэл	29	129.4	26	151.8
5	Талх, нарийн боовны үйлдвэрлэлт	8	119.0	4	26.0
6	Блок үйлдвэрлэх	10	110.0	5	31.0
7	Малын үйлдэр сайжруулах	14	97.0	7	52.0
8	Авто, засвар, сэлбэг	11	87.0	10	97.5
9	Нийтийн хоол	14	69.5	5	39.0
10	Газар тариалан	14	91.0	10	97.0
11	Бусад	31	227.0	28	194.2
	Нийт	212	1462.2	139	945.5

Төсөл сонгон шалгаруулалтыг 2019, 2020 оныг хамруулан үзэхэд Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоогүй, жижиг дунд үйлдвэрлэл шинээр бий болох боломж байгаа эсэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн эсэх, гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байгаа эсэх, төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байгаа эсэхийг огт харгалзаж үзэлгүй зөвхөн хурлын тэмдэглэл үйлдэн төсөл сонгон шалгаруулсан байна.

Аудитаар СХС хариуцсан мэргэжилтнүүд төсөл хүлээн авсан бүртгэл хөтлөөгүй, зөвлөлийн хурлын тэмдэглэлд ирсэн төслийн тоог бүрэн бичээгүй, шалгараагүй төслийг иргэнд албан бичгээр мэдэгдээгүй, зээлийн барьцаанд авсан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний бүртгэл хөтөлж, эх хувийг битүүмжлэн хадгалаагүй, зээлдэгч нарын хувийн хэрэг дотор хавсаргасан байгаа нь үрэгдэх, хадгалалт хамгаалалтад тавих хяналт сулрах эрсдэл үүссэн, мөн хувийн хэргийг журамд заасны дагуу боловсруулан цэгцэлж, дугаарлан, хяналт хийсэн тухай бүр зээлдэгч нарын хувийн хэрэгт тэмдэглэл, баяжилт хийгээгүй байна.

#### Аудитын илрүүлэлт

- Зарим сумын СХС өмнөх онд СХС-аас зээл авсан, зээл, хүүгийн эргэн төлөлт төлөгдөөгүй зээлдэгч нарт нэмж зээл олгосон. Тухайлбал: Баян-Овоо сум 2017.02.2 нд Иргэн Г.Түмэнжаргалд “Үслэг эдлэл” төсөлд 3.0 сая төгрөгийн зээл олгосон ба 2018.12.31-ийн байдлаар зээлийн үлдэгдэл 3.2 сая төгрөг байхад түүний гэр бүлийн хүн болох нөхөр А.Мэндбаярт 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулан Г.Түмэнжаргалын зээлийн үлдэгдлийн суутган тооцож 17.0 сая төгрөг олгосон. Хүрээмарал сумын СХС-аас 2017.12.21-нд иргэн Д.Шийрэвдоржид “арьс, шир боловсруулах” төсөлд 4.0 сая төгрөг олгосон ба зээлийн үлдэгдэлтэй байхад 2019 оны 4 сард нэмж 4.0 сая



төгрөг олгосон зөрчил илэрлээ. Төсөл сонгон шалгаруулах комисст хариуцлага тооцуулах зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

- Баянхонгор, Баян-Овоо, Баянбулаг, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр, Жаргалант, Жинст, Хүрээмарал, Өлзийт сумын СХС-аас орон тооны бус зөвлөл сонгон шалгаруулсан 26 төсөл ажлын байр нэмэгдүүлэх талаар тодорхой тооцоолол байхгүй байгаа нь журмын 4.3.6<sup>6</sup> дахь заалтыг зөрчсөн байна.
- Баянхонгор, Баян-Овоо, Баянбулаг, Баянцагаан, Баянлиг сумын 16 төсөлд журмын 4.3.5 дахь “төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх;” заалтыг хэрэгжүүлэх арга замыг төсөлд тусгаагүй байхад төслийг сонгон шалгаруулсан байгаад анхаарч цаашид төсөл сонгон шалгаруулахдаа журмын дөрөв дэх хэсгийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж байна.

1.2.3. Баянхонгор аймгийн сумдын “Сум хөгжүүлэх сан”-аас зээлдэгч нартай байгуулсан зээл, барьцааны гэрээнүүд нь “Иргэний хууль”-ийн 56 дугаар зүйл, 156 дугаар зүйл, “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 9, 10, 11, 53 дугаар зүйл, “Хөдлөх эд хөрөнгө болох эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангахгүй байна.

СХС-ийн журмын 4.5<sup>7</sup> дахь заалтын дагуу төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шалгарсан төслүүдэд зээл олгох захирамжийг сумын Засаг дарга гаргаж, зээлдэгч нартай зээлийн гэрээг байгуулжээ. Гэрээнд Эрдэнэцогт сум зээлийн хүүг жилийн 2 хувь, бусад сумууд зээлийн хүүг 3 хувь, хугацааг 36 сараар байгуулж зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн хуваарийг ихэнх сумд эхний жил нь зээлийн хүүг төлж, 2 дахь жилээс зээл, зээлийн хүүг сар бүр, зарим сум зээлийг жилд 2 удаа төлөхөөр гэрээг хийсэн байна.

Аудитаар 2019-2020 онд зээл авсан иргэдийн зээлийн хувийн хэргийг шалган үзэхэд дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

#### Аудитын илрүүлэлт

- Өлзийт сумаас бусад сумдын СХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлийн 118 барьцааны гэрээ Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2 дахь заалтад тусгагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан тохиолдолд заавал улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх” хуулийн шаардлагыг хангаагүй байх бөгөөд үүнээс шалтгаалж тус барьцааны гэрээнүүд нь дээрх хуулийн 156.3 дахь хэсэгт зааснаар “хүчин төгөлдөр бус” гэрээнд тооцогдох нөхцөл байдал үүссэн байна. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, барьцааны гэрээ бүрийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх” зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.
- Баянхонгор, Баянбулаг, Баян-Өндөр, Баянцагаан, Богд, Баянлиг, Бөмбөгөр, Жаргалант, Жинст, Хүрээмарал, Өлзийт, Гурванбулаг сумын 20 зээлдэгчийн

<sup>6</sup> тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх

<sup>7</sup> Журмын 4.5. Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн сумын Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана.



- барьцааны гэрээнд зээлдэгч өөрийн бус гуравдагч этгээдийн хөрөнгийг барьцаалуулсан боловч гуравдагч этгээдээс “хөрөнгийг нь барьцааны гэрээнд барьцаалуулах эрхийг зээлдэгчид олгосон” зөвшөөрөл, итгэмжлэлийг хийлгэх тухай шаардлагыг зээлдэгч нарт тавьж ажиллаагүй байна. Эдгээр үйлдлүүд нь “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 9.2<sup>8</sup>” гэх заалтыг зөрчсөн байна.
- Баянхонгор, Баянбулаг, Баянцагаан, Богд, Бөмбөгөр, Жинст, Хүрээмарал, Өлзийт сумын **13** зээлдэгчийн барьцааны гэрээнд зээлдэгч нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг барьцаалуулсан байхад хамтран өмчлөгч тус бүрийн зөвшөөрөл, итгэмжлэлийг хийлгүүлэх шаардлагыг зээлдэгч нарт тавьж ажиллаагүй “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 10.1<sup>9</sup> заалтыг зөрчсөн байна.
  - Баянхонгор, Баян-Өндөр, Бөмбөгөр, Хүрээмарал, Гурванбулаг, Эрдэнэцогт сумын **39** зээлдэгчийн барьцааны гэрээнд Иргэний хуулийн 156.2, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11.1.1 дэх заалтыг тус тус зөрчин үл хөдлөх хөрөнгийн барьцааны үнийн дүнг бичээгүй байна.
  - **Баян-Овоо** сумын 2019 оны 03, 04 дугаартай, **Эрдэнэцогт** сумын 2019 оны 62 дугааруудтай зээлийн гэрээнд барьцаалагч, барьцаалуулагч талуудын эрх үүргийг тусгайлан зохицуулсан “**барьцааны гэрээ**”-г бичгээр огт үйлдээгүй байгаа нь Иргэний хуулийн 156.1.Барьцааны гэрээг бичгээр байгуулна. 156.3.Энэ хуулийн 156.1, 156.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна” гэсэн заалтыг зөрчсөн.
  - **Баацагаан** сумын 2019-2020 онд олгосон **53** зээлийн барьцааны гэрээнд, **Жинст** сумын 2019 онд олгосон **13** зээлийн барьцааны гэрээнд мал, тээврийн хэрэгсэл зэргийг барьцаалсан боловч барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийн өмчлөгчийн нэрийг бичээгүй, барьцаалсан хөрөнгийн жагсаалт үйлдээгүй байна.
  - **Баян-Овоо** сумын СХС-аас 2019 онд зээл олгохдоо 2019.01.30-нд сумын Засаг даргын захирамжаар Г.Дэлгэрсайханд 30.0 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гарч зээлийн гэрээг 30.0 сая төгрөгөөр байгуулсан боловч 27.0 сая төгрөг олгосон, иргэн Л.Намхайд 10.0 сая төгрөгийн зээл олгохоор захирамж гарч зээлийн гэрээг 10.0 сая төгрөгөөр байгуулсан боловч 4.0 сая төгрөг олгосон, С.Батбаярт 20.0 сая төгрөгийн зээл олгохоор захирамж гарч зээлийн гэрээг 20.0 сая төгрөгөөр байгуулсан боловч 2019 онд 4.9 сая, 2020 онд 5.0 сая төгрөг олгож зээлийг гэрээг олгосон зээлийн хэмжээгээр шинэчлэн байгуулаагүй зөрчил илэрлээ.

Иймд дээрх зөрчлүүдийг арилгуулах албан шаардлагыг холбогдох сумын Засаг дарга нарт хүргүүлж байна.

1.2.4 Баянхонгор аймгийн хэмжээнд СХС-аас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн нийт авлагын 50 дээш хувь нь хугацаа хэтэрсэн 7 сум байгаа нь сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийн барагдуулалт хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны эхэнд 3516.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан ба зээл, зээлийн хүүгийн авлагаас 1155.8 сая төгрөгийн авлагыг барагдуулж 211 зээлдэгчдэд 1462.2 сая төгрөгийг олгож 3924.2 сая төгрөгийн авлагын

<sup>8</sup> “Барьцааны гэрээг байгуулахдаа бусад этгээдийн зөвшөөрлийг урьдчилан авахаар хуульд заасан бол зөвшөөрлийг хуульд заасан хэлбэрээр авсан байна

<sup>9</sup> Хамтран өмчлөх дундын өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулахад барьцааны зүйлийн өмчлөгч тус бүрийн зөвшөөрлийг бичгээр авна



үлдэгдэлтэй, 2020 онд зээл, зээлийн хүүгийн орлогоос 1336.5 сая төгрөгийн авлагыг барагдуулж 139 зээлдэгчдэд 945.5 сая төгрөгийн зээлийг олгож оны эцэст 1477.8 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

СХС-аас олгосон зээлээс 2019.12.31 байдлаар хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлага 46 хувь, 2020.12.31-ны байдлаар хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлага 38.1 хувийг эзэлж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

## СХС-аас олгосон зээлийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Он	Зээл, зээлийн хүүгийн авлага	Үүнээс хугацаа хэтэрсэн		Эзлэх хувь
		зээл	хүүгийн авлага	
2019	3924.7	1734.2	73.9	46.0
2020	3642.6	1315.7	71.8	38.1

СХС-аас олгосон зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 2020.12.31-ны өдрийн байдлаар Баянговь, Эрдэнэцогт, Бууцагаан, Жаргалант, Баацагаан, Өлзийт, Баянхонгор сумуудын хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл нийт авлагын 50 дээш хувийг эзэлж байна. Иймд дээрх сумууд зээл, зээлийн эргэн төлөлтийн орлогыг хугацаанд нь төлүүлэх, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах шаардлагатай байна.

## Хугацаа хэтэрсэн зээл хамгийн өндөр 7 сум

№	Сумын нэр	Идэвхтэй, төлбөрийн нөхцөл дуусаагүй зээлдэгч		Хэвийн зээлдэгч		Чанаргүй /зээлийн гэрээ дууссан/		Шүүх болон ШШГА-нд шилжүүлсэн	
		Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ
1	Эрдэнэцогт СХСан	18	126.1	7	48.0	11	78.1	10.00	74.0
2	Бууцагаан СХСан	49	213.0	19	104.4	20	81.6	20.00	81.6
3	Баянговь СХСан	37	76.7	0	-	37	76.7	32.00	68.5
4	Жаргалант СХСан	26	190.8	13	91.3	11	99.3	10.00	89.0
5	Баацагаан СХСан	88	233.5	15	115.8	26	81.6	26.00	81.6
6	Өлзийт СХСан	30	120.5	7	50.6	10	60.4	8.00	54.9
7	Баянхонгор сум	99	578.6	44	242.1	55	336.5	55.00	336.5
	Дүн	347	1,539.2	105	652.2	170	814.3	161	786



**Баянговь сум:** 2019-2020 онд СХС-аас зээл олгоогүй ба 2019.12.31 –ны байдлаар 101.1 сая, 2020.12.31-ны байдлаар 76.7 сая төгрөгийн зээл, хүүгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна. 2019 оны СТА-аар 21 зээлдэгчийн 47.3 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагыг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосноос 2019 онд 20.9 сая, 2020 онд 26.3 сая, 2021 оны 8-р сарын 01-ны байдлаар 19.3 сая төгрөгийг тус тус барагдуулан 10 зээлдэгчийн 6,9 сая төгрөг барагдаагүй үлдэгдэлтэй байна. 2020 онд хугацаа хэтэрсэн өртэй 12 зээлдэгчийн 38.7 сая төгрөгийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэх гаргаснаар 6 зээлдэгчийн 19.0 сая төгрөгийн зээл төлөгдөж, 2 зээлдэгч шүүхэд өөрийн биеэр очоогүй байна.

**Хүрээмарал сум:** 2019 оны эхэнд харилцах дансанд 70.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 134.7 сая зээл, зээлийн хүүгийн орлого төвлөрүүлэхээс 47.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 13 иргэнд 83.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд оны эцэст 156.9 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 50.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. 2020 онд зээл, хүүгийн орлогоос 99.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 46.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 11 иргэнд 69.0 сая төгрөгийн зээл олгож оны эцэст 180.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс 27.3 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 50.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлж барагдуулсан байна. 2020 онд хугацаа хэтэрсэн 7 зээлдэгчийн 27.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа байгаа бөгөөд энэ нь шүүхэд шилжүүлсэн шүүхийн шатанд байна.

**Баянбулаг сум:** 2019 оны эхэнд 63.2 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байсан ба зээл, хүүгийн орлогоос 88.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 46.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 6 иргэнд 60.0 сая төгрөг олгосон бөгөөд оны эцэст 152.8 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүний 79.2 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна. 2020 онд зээл, хүүгийн орлогоос 119.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 74.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 16 иргэнд 111.0 сая төгрөгийн зээл олгож оны эцэст 191.6 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс 59.3 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 35.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан байна. 2020 онд хугацаа хэтэрсэн, зээлийн гэрээ дууссан 9 зээлдэгчийн 39.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнээс 4 зээлдэгчийн 34.7 сая төгрөг нь шүүхийн шийдвэр гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн байна.

1.2.5 Баянхонгор аймгийн ихэнх сумын СХС-аас олгосон зээл өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэгдсэн, Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2020 оны тайлангаар 141 ажлын байр шинээр нэмэгдэж 79 ажлын байр хадгалагдсан гэж байгаа боловч дээрх ажлын байрууд нь нийгмийн даатгалаар баталгаажаагүй байна.



Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг 2019-2020 онд аймгийн 20 сумын 212 төсөл хэрэгжүүлэгчдэд хоол үйлдвэрлэл, сүү, цагаан идээ, блок, тоосго үйлдвэрлэх, төмөр хийц үйлдвэрлэхэд зориулан 199 төсөлд 1375.7 сая, ахуйн үйлчилгээний чиглэлээр оёдол, арьс, шир гар урлал, эсгий урлал, үсчин гоо, сайхан, гутал засвар зэрэг 90 төсөлд 517.5 сая, хэвлэл мэдээлэл, уран зураг, аялал жуулчлал, авто засвар, малын үүлдэр сайжруулах зэрэг 24 төсөлд 217.5 сая төгрөг, мах бэлтгэл, бичиг хэрэг, хүнсний дэлгүүр өргөтгөх зэрэг 7 төсөлд 48.0 сая төгрөг нийт 2402.7 сая төгрөгийн зээл олгосон байна.

Төслийн зориулалт	2019 он		2020 он	
	Төсөл хэрэгжүүлэгчийн тоо	Мөнгөн дүн	Төсөл хэрэгжүүлэгчийн тоо	Мөнгөн дүн
Ахуйн үйлчилгээ	76	441.5	14	76.0
Бусад	7	48.0		
Үйлдвэрлэл	99	728.7	100	647.0
Үйлчилгээ	30	244.0	24	217.5
Нийт	212	1,462.2	138	940.5

#### Аудитын илрүүлэлт


- СХС-ийн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор олгохоор байхад сумд ижил төрлийн үйл ажиллагаанд олон төслийг сонгон шалгаруулж дунджаар 2.0-3.0 сая төгрөгийн олгож байгаа журмын 1.2 дахь заалтад нийцэхгүй байна. Тухайлбал: 2019 онд Баацагаан суманд “Сүү, цагаан идээ боловсруулах” төсөлд 16 иргэнд 44.0 сая, 2020 онд 6 иргэнд 23.5 сая, Баянхонгор сум 2019 онд оёдлын чиглэлээр 8 төсөлд 54.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

Баянхонгор аймгийн ХХААГ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, мэдээнд 2020 онд 139 төсөл хэрэгжүүлэгчид 945.5 сая төгрөг зээл олгосноор 141 ажлын байр шинээр нэмэгдэж 79 ажлын байр хадгалагдсан ба Ковид цар тахалтай холбоотойгоор зээлдэгч нарын ихэнх нь гэрээрээ үйл ажиллагаа эрхэлдэг, нийгмийн даатгал төлөгдөөгүй нь байнгын ажлын байраар хангагдсан гэж үзэх боломжгүй байна.

2019 онд Баянхонгор сумын СХС-аас 28 төсөлд 278.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноос 4 зээл хугацаанаас өмнө бүрэн төлөгдөж дээрх зээл зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэх, төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаа хэвийн явагдаж буй эсэх, зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөж буй эсэхийг тодруулахаар газар дээр нь очиж уулзалт, ярилцлага хийлээ.



## Баянхонгор суманд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс сайн хэрэгжсэн төслийн зургууд



## Аудитын илрүүлэлт

- Баянхонгор сумын СХС-аас зээл авсан иргэн Э.Д “Уран бичлэг, жааз үйлдвэрлэх” зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан ба 2021.08.19-ны өдрийн байдлаар 5.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, аудитын явцад шалгахад төсөл хэрэгжүүлэгч Улаанбаатар хотод ажилд орсон ба үйл ажиллагаа явуулаагүй,
- Иргэн Ж.Б нь “Гоёл” оёдлын цех өргөжүүлэх зориулалтаар 2019 онд 8.0 сая төгрөгийн зээл авсан ба 2021.08.19-ны байдлаар 4.5 сая төгрөгийн зээл, хүүгийн хугацаа хэтэрсэн өртэй ба аудитын явцад утсаар холбогдон ярилцлага хийхэд үйл ажиллагаагаа Улаанбаатар хотод явуулж байгаа ба зээлийг бүрэн төлж зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг буцаан авсан гэх тайлбар өгсөн байхад зээл төлөгдөөгүй, гэрчилгээг хүлээлцсэн акт байхгүй байгаа нь журмын 4.8.7<sup>10</sup> дахь заалтыг зөрчсөн байна.
- Иргэн Б.М нь “Оёдол” –ын зориулалтаар 6.0 сая төгрөгийн зээл авсан ба аудитаар үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхой бус, хаяг байршилдаа байхгүй, төсөл дээр бичигдсэн утасны дугаараар холбогдож чадаагүй болно. 2021.08.19-ны байдлаар хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлага 4.2 сая төгрөг болно. Иймд үйл ажиллагаа явуулаагүй дээрх 3 зээлдэгчийн 16.7 сая төгрөгийг төсөл хэрэгжүүлэгчээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож байна.
- Богд сумын СХС-аас 2019 онд иргэн Б.Цогзолмаагийн “Хүнсний дэлгүүрийн төсөл”-д 12.0 сая төгрөгийн зээл олгосныг Санхүүгийн хяналт, аудитын алба “СХС-ын 2019 хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт” –д хийсэн аудитаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.
- Богд сумын СХС-аас 2019 онд иргэн Н.Амаржаргалын “Хүнсний дэлгүүрийн төсөл”-д 3.0 сая төгрөг, Баян-Овоо сумын СХС-аас 2019 онд иргэн Л.Намхайгийн “Супер маркетын төсөл” –д 4.0 сая төгрөг олгосон нь журмын 4.3.1-т ” тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн

<sup>10</sup> 4.8.7. барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг эх хувиар хавсаргах



үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх” заалттай нийцэхгүй байгаа тул төсөл хэрэгжүүлэгч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоож байна.

**Зарим сумын хяналтын зөвлөл сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, тайланг ИТХ-аар тайлагнаж хэлэлцүүлээгүй байна.**

*2.1.1 Сумдын хяналтын зөвлөл “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн хэрэгжилт, үр дүнд” хяналт тавиагүй, сумын ИТХ-д ажлаа тайлагнаагүй байна.*

Сумд СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг СХС-гийн журмын 3.3.2<sup>11</sup>-т заасны дагуу байгуулсан ба аудитаар сумдаас 2019,2020 оны СХС-аас олгосон зээлийн зориулалт, зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих эрх бүхий СХС-гийн хяналтын зөвлөлийн тайланг авч шалгахад Баянговь, Бууцагаан, Богд, Бөмбөгөр, Жинст, Өлзийт, Эрдэнэцогт, Баянбулаг, Баацагаан сумын хяналтын зөвлөл нь СХС-гийн журмын 5.3.2<sup>12</sup> -т заасны дагуу сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тайланг ирүүлээгүй байна. Иймд төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, СХС-гийн үйл ажиллагаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг сумдын ИТХ-д хүргүүлэв.

2.1.2 Сумдын СХС-аас авсан зээлийн мэдээллийг СХС-ийн программд оруулахдаа санхүүгийн тайланд байгаа зээл, зээлийн хүүгийн авлагаас зөрүүтэй оруулж, зээлдэгч нартай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулахгүй байна.

Баянхонгор аймгийн ХХААГ-ын даргын 2020 оны 05 сарын 15-ны өдрийн А/19 дугаар “Сум хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалт, үйл ажиллагаа, программ ашиглалтад хяналт, шалгалт хийх тухай” тушаалын дагуу батлагдсан удирдамжаар Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Хүрээмарал, Заг, Гурванбулаг сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн сангийн программ ашиглалт болон 2019 онд зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаанд хэсэгчлэн хяналт тавьж арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан байна.

<sup>11</sup> Журмын 3.3.2. сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;

<sup>12</sup> Журмын 5.3.2. сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;



Баянхонгор аймгийн ХХААГ-аас СХС-ийн программын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс ХХААХҮЯ-тай хамтран онлайн сургалтыг 2020 оны 3-р сард зохион байгуулж 11 сумын мэргэжилтнүүдийг хамруулсан.

СХС-ийн программ ашиглалт 2019-2020 оны зээл олголтыг оруулсан байдлыг аймгийн ХХААГ-ын мэргэжилтний программаас тулган шалгахад бүх сумдын СХС-аас 2019-2020 онд олгосон зээлийн мэдээлэл программд бүрэн орсон бөгөөд Баян-Овоо сум 1 зээлдэгчид он дамжуулан зээл олгосон, Хүрээмарал сум СХС-аас өмнө нь зээлтэй иргэнд зээл олгосон, Богд сум 2018 онд олгосон зээлийг дутуу бүртгэсний нөхөн бүртгэсэн зэргээс программд зөрүүтэй бүртгэсэн харагдаж байна.

СХС-аас 2019-2020 онд олгосон зээлийн мэдээллийг программд оруулсан байдал

№	Сумын нэр	2019 онд олгогдсон зээл		СХС программд оруулсан дүн		Зөрүү		2020 онд олгогдсон зээл		СХС программд оруулсан дүн		Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Галуут СХСан	7	58.0	58.0	7	-	-	10	78.0	10	78.0	-	-
2	Баян-овоо СХСан	8	112.9	120.9	8	(8)	-	3	12.2	2	7.2	1	5.0
3	Эрдэнэцогт СХСан	5	57.0	57.0	5	-	-	7	48.0	7	48.0	-	-
4	Бууцагаан СХСан	16	98.5	98.5	16	-	-	-	-	-	-	-	-
5	Жинст СХСан	17	144.5	144.5	17	-	-	-	-	-	-	-	-
6	Богд СХСан	11	67.0	72.0	12	(5)	(1)	3	18.0	3	18.0	-	-
7	Баянлиг СХСан	15	88.0	88.0	15	-	-	0	-	-	-	-	-
8	Баянговь СХСан	-	-	-	-	-	-	0	-	-	-	-	-
9	Гурванбулаг СХСан	-	-	-	-	-	-	9	73.0	9	73.0	-	-
10	Жаргалант СХСан	7	67.0	67.0	7	-	-	6	42.0	6	42.0	-	-
11	Заг СХСан	-	-	-	-	-	-	13	53.0	13	53.0	-	-
12	Баацагаан СХСан	37	108.0	108.0	37	-	-	17	45.5	17	45.5	-	-
13	Бөмбөгөр СХСан	17	94.5	94.5	17	-	-	11	51.5	11	51.5	-	-
14	Өлзийт СХСан	10	54.0	54.0	10	-	-	0	-	-	-	-	-
15	Хүрээмарал СХСан	14	83.0	79.0	13	4	1	11	69.0	11	69.0	-	-
16	Баянбулаг СХСан	6	60.0	60.0	6	-	-	16	111.0	16	111.0	-	-
17	Шинэжинст СХСан	0	-	-	-	-	-	8	164.0	8	164.0	-	-
18	Баянцагаан СХСан	5	40.0	40.0	5	-	-	17	122.3	17	122.3	-	-
19	Баян-өндөр СХСан	8	51.8	51.8	8	-	-	8	58.0	8	58.0	-	-
20	Баянхонгор СХСан	29	278.0	278.0	29	-	-	0	-	-	-	-	-
	Нийт	212	1,462.2	1,471.2	212	(9)	-	139	945.5	138		1	5.0

Баянхонгор аймгийн сумдын СХС-ийн санхүүгийн тайланг сумдын ТТЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж байна. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас сумдын СХС-ийн 2019-2020 оны санхүүгийн тайланг санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамруулж үе шатны ажил хийгдсэн.

Сумдын СХС-ийн нягтлан бодогч нар зээлийн хүүгийн орлогыг авлагаар бүртгэхтэй харилцан адилгүй бүртгэдэг, зарим сум зээл олгохдоо хүүг суутган авдаг бол зарим сумд зөвхөн олгосон зээлийн хэмжээгээр авлагаар бүртгэдэг зэргээс шалтгаалан 7 сум СХС-ийн 150 зээлдэгчийн зээл, хүүгийн авлага 36.5 сая төгрөгийг



дутуу бүртгэснийг 2020 оны санхүүгийн тайланд авлагаар нэмж бүртгэсэн байна.

Үүнд:

- Баян-Өндөр сумын СХС 27 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 8.5 сая төгрөг.
- Өлзийт сум 1 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 0.06 сая төгрөг.
- Богд сум 38 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 3.5 сая төгрөг.
- Баян-Өндөр сум 27 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 8.5 сая төгрөг.
- Баянбулаг сум 14 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 3.7 сая төгрөг.
- Галуут сум 36 зээлдэгчийн зээл, зээлийн хүүгийн авлага 6.6 сая төгрөг
- Баацагаан сум 7 зээлдэгчийн зээлийн хүүгийн авлага 5.6 сая төгрөг

#### Аудитын илрүүлэлт

- Баянхонгор сумын СХС 2020.12.31-ны өдрийн байдлаар 103 зээлдэгчийн 563.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан байхад авлагын үлдэгдлийг аудитаар дахин зээлдэгч тус бүрээр хувийн хэрэгтэй тулган тооцооллыг давтан гүйцэтгэхэд 578.6 сая төгрөг буюу 15.3 сая төгрөгөөр алдаатай тайлагнасан байна. Тухайлбал: Зээлдэгч Д.Бямбасүрэн Шүүхээс тогтоосон зээл, хүүгийн үлдэгдэл 26.9 сая төгрөг байхад санхүүгийн тайланд 18.0 сая төгрөгөөр, Г. Байгалмаа 2020 онд 1.6 сая төгрөг төлсөн байхад 2020 оны авлагаас хасаж бүртгээгүй, Рэдмаа 2020 онд зээлийн үлдэгдэл 3.1 сая төгрөгийг барагдуулсан байхад 3,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Баянхонгор менежмент групп 2020 онд 17.0 сая төгрөг төлж авлагыг бүрэн барагдуулсан байхад санхүүгийн тайланд 15.2 сая төгрөгийг авлагын үлдэгдэлтэйгээр, 49 зээлдэгчийн 33.0 сая төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2<sup>13</sup>, 14.4.5<sup>14</sup>, УСНББОУС 15 "Харилцагч байгууллагатай тооцооны үлдэгдлийн баталгааг улирал, жилийн эцэст тулган баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдэнэ" гэсэн стандартыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд Баянхонгор сумын Засаг дарга, СХС хариуцсан мэргэжилтэнд тайланд хугацааны эцэст авлагын үлдэгдлийг зээлдэгч нэг бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, 2021 оны 3-р улиралд багтаан санхүүгийн тайланд авлагын үлдэгдлийг залруулан бүртгэх албан шаардлага хүргүүлж байна.

2.1.3 Зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа барагдуулаагүй, төсөл хөтөлбөрийг зориулалт бусаар зарцуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцоогүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд СХС-аас олгосон зээлээс 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 56%, 2020 оны жилийн эцсийн байдлаар 63% нь зээлийн эргэн төлөлт хэви йн гэрээний хугацаанд эргэн төлөлт хийгдэж байгаа ба 2019 онд нийт зээлийн үлдэгдлийн 36%, 2020 онд нийт зээлийн үлдэгдлийн 33% чанаргүй зээл эзэлж байгаа байна.

<sup>13</sup> бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,

<sup>14</sup> бүх орлогыг бүртгэнэ.



Гэрээний хугацаа хэтэрсэн чанаргүй зээлээс 2019 онд 50 хувь буюу 162 зээлдэгчийн 702.5 сая төгрөг, 2020 онд 221 зээлдэгчийн 1051.6 сая төгрөгийн зээлийг Шүүх болон ШШГА -руу шилжүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт

- Засгийн газрын 2016 оны 153 дугаар журмын 6.1 дах заалт “Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд сангаас дахин зээл олгохгүй” заалтыг Баян-Овоо, Хүрээмарал сумын СХС хэрэгжүүлээгүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 2 иргэнд зээл 21.0 сая төгрөгийн зээл нэмж олгосон.
- 2020.12.31-ны байдлаар сумдын СХС-аас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, нийт зээлийн багцад чанаргүй зээлийн багц 50 дээш хувийг эзэлж буй Баянговь, Эрдэнэцогт, Баянхонгор, Жаргалант, Өлзийт сумд байхад журмын 6.2 дахь “Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### СХС-ийн зээлдэгчийн зээлийн ангиллын мэдээлэл

/сая.төгрөг/

Эдийн засгийн үзүүлэлт	Идэвхитэй буюу төлбөрийн нөхцөл дуусаагүй зээлдэгч		Үүнээс									
			Хэвийн зээлдэгч		Хугацаа хэтрэлт /Зсараас дээш эргэн төлөлт хийгээгүй/		Чанаргүй /буюу зээлийн гэрээ дууссан, /		Үүнээс			
									Шүүхийн шатанд яваа		Шүүхийн шийдвэр гарсан	
Он	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ
2019	816	3,877.4	353	2,188.9	114	276.2	349	1,412.4	61	240.1	101	462.37
2020	748	3,642.6	373	2,283.0	112	181.5	264	1,192.0	132	505.4	89	546.14

#### СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ



№	Эдийн засгийн үзүүлэлт  Сумдын нэр	Идэвхитэй буюу төлбөрийн нөхцөл дуусаагүй зээлдэгч  Зээлдэгчийн тоо зээлийн хэмжээ		Үүнээс						Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь
				Чанаргүй /зээлийн гэрээ дууссан/  Зээлдэгчийн тоо зээлийн хэмжээ		Үүнээс				
						Шүүхийн шатанд яваа		Шүүхийн шийдвэр гарсан		
1	Баянговь СХСан	37	76.7	37	76.7	23	40.3	9	28.2	100%
2	Эрдэнэцогт СХСан	18	126.1	11	78.1	5	31.4	5	42.6	62%
3	Баянхонгор сум	99	578.6	55	336.5	29	186.1	26	150.4	58%
4	Жаргалант СХСан	26	190.8	11	99.3	0	0.0	10	89.0	52%
5	Өлзийт СХСан	30	120.5	10	60.4	4	8.4	4	46.5	50%
6	Баянлиг СХСан	24	134.3	8	53.8	1	4.8	3	30.3	40%
7	Бууцагаан СХСан	49	213.0	20	81.6	17	64.0	3	17.6	38%
8	Гурванбулаг СХСан	29	162.2	16	62.1	5	25.4	7	24.3	38%
9	Баацагаан СХСан	88	233.5	23	67.1	23	67.1	0	0.0	29%
10	Баян-овоо СХСан	23	159.3	13	44.7	0	0.0	7	18.5	28%
11	Заг СХСан	39	126.7	11	30.9	10	27.0	0	0.0	24%
12	Баянбулаг СХСан	33	191.6	9	39.3	1	0.3	4	34.7	21%
13	Галуут СХСан	37	200.7	5	34.1	0	0.0	5	34.1	17%
14	Хүрээмарал СХСан	39	180.7	7	27.3	7	27.3	0	0.0	15%
15	Богд СХСан	36	129.5	5	19.4	1	2.6	0	0.0	15%
16	Бөмбөгөр СХСан	35	159.5	7	23.7	3	10.1	0	0.0	15%
17	Баян-өндөр СХСан	29	157.6	7	23.1	0	0.0	3	7.7	15%
18	Жинст СХСан	19	127.8	2	18.0	1	3.2	1	14.9	14%
19	Шинэжинст СХСан	11	176.1	3	13.0	1	5.7	2	7.3	7%
20	Баянцагаан СХСан	47	197.3	4	2.8	1	1.7	0	0.0	1%
	Дүн	748	3,642.6	264	1,192.0	132	505.4	89	546.1	

2.2.1 Өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн актын биелэлт 85 хувь, Монгол банкны мэдээллийн санд орсонтой холбоотойгоор чанаргүй зээл 78.9 сая төгрөгөөр төлөгдсөнийг аудитын үр өгөөжөөр хүлээн зөвшөөрч бүртгэлээ.

1. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад өгсөн “Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллах” зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.03-ны өдрийн 05 тоот “Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх, эргэн төлөлтийг эрчимжүүлэх тухай” албан даалгаврыг аймгийн ХХААГ болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгон өгсний үр дүнд сум бүр албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж ирүүлсэн байна.

2. Баянхонгор аймгийн хэмжээнд СХС-ийн программ хангамжийг бүрэн нэвтрүүлж улмаар 2011-2020 онд СХС-аас зээл авсан зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчийн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд нэгтгэх ажлыг



2021 онд зохион байгуулсан бөгөөд Монгол банкнаас хэрэгжүүлсэн зээлийн мэдээллийн санд тохируулга хийх шийдвэрийг чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчдэд хүргүүлж ажилласны үр дүнд тус сангаас зээл аваад чанаргүй зээлийн ангилалд орсон 30 зээлдэгч 2021.06.25-2021.07.01 дотор хугацаа хэтэрсэн чанаргүй зээл 78.9 сая төгрөгийг бүрэн барагдуулж муу зээлийн түүхийг арилгаж үр өгөөж гарсан байна.

3. СХС-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх онуудын СХС-аас хөнгөлөлттэй зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нараас 17 сумын 251 иргэнд зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 605.7 сая төгрөгийн, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 32.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүг төлүүлэх төлбөрийн актыг тус тус тогтоосон байна. Аудитаар актын биелэлтийг шалгахад 2019 оны төлбөрийн актаас 2020 онд 450.6 сая төгрөг, 2021 оны эхний 6 сарын байдлаар 65.2 сая төгрөгийн акт барагдаж 89.6 сая төгрөгийн акт төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна. Үүнийг сум сумаар нь харуулбал Бөмбөгөр сумын 2 зээлдэгчийн 5.2 сая төгрөг, Баян-Овоо сумын 8 зээлдэгчийн 23.5 сая /нас барсан -1, 7.4 сая/ Гурванбулаг сум 2 зээлдэгчийн 13.5 сая /нас барсан-2/, Богд сум 1 зээлдэгчийн 2.3 сая, Өлзийт сум 2 зээлдэгчийн 9.1 сая төгрөгийн төлөгдөөгүй актын үлдэгдэлтэй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 90 хувь, актын хэрэгжилт 85 хувь, аудитаар Монгол банкны мэдээллийн санд орсонтой холбоотойгоор чанаргүй зээл 78.9 сая төгрөгөөр төлөгдсөнийг аудитын үр өгөөжөөр хүлээн зөвшөөрч бүртгэлээ.

Аудитаар нийт 1348.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 103.0 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 1209.3 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай 39 албан шаардлага, 36.6 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлэв.



## АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр ашиг 2019-2020”-т хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. СХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” –ын 2.1.3<sup>15</sup> заасны дагуу тухайн жилд орох зээлийн хүүгийн орлого, СХС-ийн үйл ажиллагааны зардлыг журмын 1.8<sup>16</sup> дахь заалтыг үндэслэн төлөвлөөгүй байна.

2. Сумууд сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг ИТХ-аар баталж байгаа боловч ихэнх сумын төсөл сонгон шалгаруулах комисс ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, хүрэх үр дүн тодорхой бус, ажлын байр нэмэгдүүлэх тооцоолол хийгээгүй төслүүдийг сонгон шалгаруулжээ.

3. Сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дээрх журмын 3.3.3<sup>17</sup> -д заасан бүрэлдэхүүнээр шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

4. СХС-аас олгосон зээл өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэгдсэн, 141 ажлын байр шинээр нэмэгдэж 79 ажлын байр байна.

5. Баянхонгор аймгийн хэмжээнд 2020.12.31-ний байдлаар СХС-аас олгосон зээл, хүүгийн авлагын 35.4 хувь буюу 1284.0 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлага байгаа нь СХС-аас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

6. Баянхонгор аймгийн сумдын “Сум хөгжүүлэх сан”-гаас олгож байгаа зээлдэгч нартай байгуулсан зээл, барьцааны гэрээнүүд нь “Иргэний хууль”-ийн 56 дугаар зүйл, 156 дугаар зүйл, “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 9, 10, 11, 53 дугаар зүйл, “Хөдлөх эд хөрөнгө болох эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангахгүй байна.

7. Сумдын СХС-аас авсан зээлийн мэдээллийг СХС-ийн хариуцсан ажилтнууд программд оруулахдаа санхүүгийн тайланд байгаа зээл, зээлийн хүүгийн авлагаас зөрүүтэй оруулж, зарим сумд зээлдэгч нартай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

<sup>15</sup> сангаас олгосон зээлийн хүүгийн орлого

<sup>16</sup> Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

<sup>17</sup> сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах



8. Зарим сумдын Засаг дарга, сангийн хяналтын зөвлөл журмаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй СХС-ийн тайланг ИТХ-д тайлагнаагүй байна.

АУДИТОР



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

Б.МӨНХБАТ





## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр ашиг 2019-2020"-т хийсэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### Нэг. Сумдын ИТХ-ын дарга нарт

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд ажиллах багийн төлөөллийг Засгийн газрын 2016 оны Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.4.1<sup>18</sup> заалтыг хэрэгжүүлэн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгон батлах.

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, хяналт шалгалт хийсэн ажлын тайланг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн иргэдэд нээлттэй мэдээлж, хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах талаар сумын Засаг даргатай хамтран тодорхой ажил зохион байгуулах.

### Гурав. Сумдын Засаг дарга нарт

1. СХС-ийн эх үүсвэр, үйл ажиллагааны зардлыг ангиллаар нь үндэслэлтэй тооцож журмын 3.5.7<sup>19</sup> дахь заалтын дагуу сумын ИТХ-аар батлуулж байх.

2. СХС-аас зээл олгохдоо үр дүнг тооцох боломжгүй олон жижиг төсөл арга хэмжээнд бус журмын 4.3<sup>20</sup> т заасан шалгуур хангасан, сумын тэргүүлэх чиглэлд нийцсэн орон нутагт хэрэгжих боломжтой төсөлд зээл олгож байх.

3. Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй зээлдэгч нарт нэмж зээл олгодог, ШШГГ-аас зээлийг бүрэн төлөөгүй байхад эгүүлэн татах, зээлийн үлдэгдэлтэй байхад барьцаа хөрөнгийг чөлөөлдөг зэрэг хууль бус үйлдлийг таслан зогсоох

4. Сумдын СХС-аас зээл авч буй зээлдэгч нартай "Иргэний хууль"-ийн 56 дугаар зүйл, 156 дугаар зүйл, "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн 9, 10, 11, 53 дугаар зүйл, "Хөдлөх эд хөрөнгө болох эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн 10 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан зээл, барьцааны гэрээг байгуулж ажиллах.

<sup>18</sup> 3.4.1. зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн сонгосон байх

<sup>19</sup> 3.5.7. сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах

<sup>20</sup> 4.3. Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл дараах шалгуурыг хангасан байна



Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2021 оны 11-р сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

АУДИТОР

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ

Б.МӨНХБАТ



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас 70-44-23-45

2021.09.17 № 1/368  
талбай \_\_\_\_\_ -нм № \_\_\_\_\_ т

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Баянхонгор сумын Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны хөрөнгийн зарцуулалт, үр ашигт хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын зүгээс холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зээл, хүүг бүрэн төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа болно.

Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг дахин давтахгүй.

ДАРГА



Ж.МӨНХСОЁЛ

*Ахлах аудитор  
Н. Антантураг  
Тиймэнэ боллох  
даргын газар хариуцах  
2021.09.17*

7210562



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**


61101 Баянхонгор аймаг  
Баянхонгор сум, Рашаант баг  
Утас 7044 2478

2021.09.17 № 3/277

төрийн \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 онуудын хөрөнгийн зарцуулалт, үр ашигт хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд Баянхонгор сумын сум хөгжүүлэх сангийн зээл олголтын мэдээлэл зөрүүтэй, мөн аудитын дүгнэлтийн 4 дүгээрт "Ажлын байрууд нь нийгмийн даатгалаар баталгаажуулаагүй байна." гэсэн нь хөнгөлөлттэй зээл олгох журамд энэхүү асуудлыг тодорхой тусгаагүй болно. Иймд Баянхонгор сумын саналыг авч, гүйцэтгэлийн тайланд тусгаж өгнө үү.

ДАРГА  Ж БАТТӨР  


*Ахлах аудитор  
Н. Анхцогтсүх  
Мингвагийн а  
хөдөлгөөн  
сангийн  
хөгжүүл.*

• 642105150